



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ**



АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ

Салбар:

Зам тээвэр

Мэргэжлийн нэр:

Автомашинь засварчин

Улаанбаатар хот

2018 он

Ажил мэргэжлийн лавлах: Автомашины засварчин

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй L3243-MON “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулав.

ISBN:

Ажил мэргэжлийн лавлахын баталгаажилт

Үндэсний ажил мэргэжлийн ангилал тодорхойлолт (YAMAT 08)-ын	8211-20
Хөтөлбөрийн индекс:Боловсролын Олон Улсын Стандарт Ангилал (ISCED-13):	Тээврийн хэрэгсэлийн үйлдвэрлэл ба засвар 0716-606
Баталсан байгууллага, огноо:	МБСҮЗ-ийн 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 02 дугаар тогтоол
Баталгаажуулсан байгууллага, огноо:	Монголын Авто Замчдын Холбоо 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдөр
Хянан засварласан хувилбар, огноо	№ 01 оны ... дугаар сарын ны өдөр
Хянан засварлах хугацаа	Мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн тогтоож, өөрчлөлт орох эсвэл шаардлагатай тохиолдол бүрт
Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулсан аргачлал	ДАКУМ шинжилгээний аргачлал

Энэхүү ажил мэргэжлийн лавлахыг ХНХЯ-ны зөвшөөрөлгүйгээр олшруулах, дахин хэвлэхийг хориглоно.

АГУУЛГА

	Хуудасны дугаар
Өмнөх үг	3
Товчилсон үгийн тайлбар	4
1. Ажил мэргэжлийн лавлахын хэрэглээ	5
2. Ажлын байрны товч тодорхойлолт	6
3. Ажлын байрны тухай мэдээлэл	6
3.1 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл	
3.2 Ажлын байранд тавигдах шаардлага	
3.3 Ажлын байранд шаардагдах боловсролын бичиг баримт	
3.4 Ажлын байранд шаардагдах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд материал	
4. Ажлын байранд мөрдөгдөх норматив ишлэл	7
5 Хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшил	8
5.1 Мэдлэг	
5.2 Ур чадвар	
5.3 Хандлага, төлөвшил	
6. Үүрэг ба ажилбарын жагсаалт	9
7. Ажлын байр бусад албан тушаалын уялдаа холбоо	16
8. Техникийн эсвэл мэргэжлийн боловсрол олгох байгууллага болон ажил олгогчийн мэдээлэл	16
9. Автомашины засварчин мэргэжлээр ажил мэргэжлийн лавлахыг боловсруулж, баталгаажуулсан төлөөлөл	17

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх чиглэл хөдөө аж ахуй, барилга, зам тээврийн салбарт мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй L3243-MON “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд “Автомашинны засварчин” мэргэжлийн ажил мэргэжлийн лавлахыг боловсруулав.

Мэргэжлийн боловсрол, сургалтад оролцогч талууд төрийн байгууллага, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн сургалтын байгууллага, ажил олгогч, мэргэжлийн холбоод, ажил хайгч, оюутан, суралцагч зэрэг хэрэглэгчдийн нийтлэг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн энэхүү ажил мэргэжлийн лавлахыг боловсруулсан бөгөөд лавлахыг хэн хэрхэн ямар хэрэгцээнд зориулан ашиглаж болохыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

- төрийн байгууллага хөдөлмөр эрхлэлт, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын талаар бодлого боловсруулах, хянах, хөдөлмөрийн харилцаатай холбогдох мэдээллийг авах, ажилтны ур чадварыг үнэлэхэд;
- ажил олгогчид нь ажлын байрны тодорхойлолт, аж ахуйн нэгж байгууллагын дотоод дүрэм, журам боловсруулахад;
- политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн сургалтын байгууллага, түүнчлэн холбогдох их, дээд сургуулиуд нь сургалтын хөтөлбөрөө боловсруулах, төгсөгчдийн ур чадварын үнэлгээ хийх, багш нарыг сургаж бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэхэд;
- ажил хайгч иргэд, суралцагчид нь ажлын байрны хэрэгцээ шаардлага, түүнд шаардагдах ур чадвар, мэдлэг, хандлага төлөвшил, хөдөлмөрийн нөхцлийн талаарх мэдээллийг олж авахад ажил мэргэжлийн лавлахыг ашиглаж болно.

Ажил мэргэжлийн лавлах нь ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, тавигдах шаардлага, мөрдөж ажиллах стандарт, ашиглах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажилтны эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагаас гадна мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогчдын талаарх ерөнхий мэдээллийг агуулсан болно.

Мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшил, хийж гүйцэтгэх үүрэг, ажилбарыг салбарын зөвлөх, мэргэжилтэн, томоохон аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогчид, мэргэжлийн холбоодын төлөөлөл, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн мэргэжлийн багш нарын мэдлэг, туршлагад тулгуурлан ажил мэргэжлийн дүн шинжилгээний ДАКУМ арга зүйгээр боловсруулсан.

Монгол Улсын мэргэжлийн боловсрол, сургалтын салбар нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд бодитоор нийцэж, төр, хувийн хэвшлийн түншлэл, шинэ техник технологи, шинэлэг арга зүйд тулгуурлан хөгжих болтугай.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
МБСБХЗГ	Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АМЛ	Ажил мэргэжлийн лавлах
АМДШ	Ажил мэргэжлийн дүн шинжилгээ
АХБ	Азийн хөгжлийн банк
БАЗТ	Бүсийн арга зүйн төв
МБС	Мэргэжлийн боловсрол, сургалт
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МБСҮЗ	Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөл
МБССЗ	Мэргэжлийн боловсрол сургалтын салбар зөвлөл
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
ҮМХ	Үндэсний мэргэшлийн хүрээ
ХЭУЧД төсөл	Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл

1. Ажил мэргэжлийн лавлахын хэрэглээ

Энэхүү ажил мэргэжлийн лавлах нь ажлын байранд тавигдах шаардлага, мөрдөж ажиллах стандарт, ашиглах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажилтны эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагаас гадна мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогчдын талаарх ерөнхий мэдээллийг агуулсан болно. Уг лавлагаас дараах хэрэглэгчид шаардлагатай мэдээллийг олж авна. Үүнд:

Хэрэглэгч	Лавлагаас авах мэдээлэл
Төрийн байгууллага	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг үндэсний болон салбар, бүс, орон нутгийн түвшинд тодорхойлж боловсруулах; • Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт боловсруулах, ажлын байр, хөдөлмөрийн харилцааг зохицуулах асуудалтай холбогдох мэдээллийг авах; • Ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтны ур чадварыг үнэлэх; • Иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх зорилгоор ашиглах.
Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон Политехник коллеж	<ul style="list-style-type: none"> • Ажил олгогчийн шаардлагад нийцсэн сургалтыг зохион байгуулах; • Тухайн мэргэжлийн чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, багшийг сургаж бэлтгэх; • Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх; • Ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах, үйлдвэрлэлийн дадлагыг хамтран зохион байгуулах.
Ажиллолгогч	<ul style="list-style-type: none"> • Ажлын байрны тодорхойлолт, ажилтан сонгон шалгаруулах шалгуурыг боловсруулах; • Ажилтныг үнэлэх, үйл ажиллагааны гүйцэтгэлийн түвшинг үнэлэх, цалинг тогтоох; • Ажлын ачаалал, нормыг тогтоох; • Ажилтныг давтан сургах, мэргэшүүлэхтэй холбогдсон сургалтын хэрэгцээг тодорхойлох, захиалгат сургалтыг төлөвлөх; • Сургалтын байгууллагатай хамтран ажиллах; • Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага дээрх дадлагажуулах сургалтыг зохион байгуулах.
Иргэн ба ажил хайгч	<ul style="list-style-type: none"> • Ажлын байрны нөхцөл, тавигдаж буй шаардлагын талаар мэдээлэл авах; • Ажлын байранд гүйцэтгэх үндсэн үүрэг, ажилбар, ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн талаар мэдээлэл авах; • Мэргэжлийнхээ хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшлийн талааройлголт авах; • Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тухай мэдээлэл авах; • Ажлын байр, аж ахуйн нэгж байгууллагын талаар мэдээлэл авах.

2. Ажлын байрны товч тодорхойлолт

Автомашинны засварчин нь үйлчлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн мастер, механикийн удирдлагаар хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, төрөл бүрийн авто тээврийн хэрэгслийн гэмтэл, саатлыг оновчтой тодорхойлон засварлаж, арчилж тордон техникийн чанартай үйлчилгээ үзүүлнэ.

3. Ажлын байрны тухай мэдээлэл

3.1 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл

- Автомашинны засварчин нь автомашинны засварын газарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг бүрэн хангасан орчин нөхцөлд ажиллана.
- Автомашинны засварчин нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна.
- Автомашинны засварын ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, тогтоосон норм, нормативын дагуу явуулна.
- Машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлага, зааварчилгаа болон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангасан нөхцөлд ажиллана.
- Автомашинны засварчин нь үйлдвэрлэл, ажил үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамрагдана.
- Автомашинны засварчин нь хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллана.

3.2 Ажлын байранд тавигдах шаардлага

- Автомашинны засварчин мэргэжлийн боловсролтой, 18 нас хүрсэн иргэн байна.

3.3 Ажлын байранд шаардагдах боловсролын бичиг баримт

- Мэргэжлийн үнэмлэх болон чадамжийн гэрчилгээ шаардагдана.

3.4 Ажлын байранд шаардагдах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд материал

- **Машин механизм:** Автомашин ачигч гэх мэт.
- **Тоног төхөөрөмж:** Автомашинны өргүүр, хөдөлгүүрийн суурь, автомашинны хөдөлгүүр өргөгч, тос юүлэгч, дугуйтай тэргэнцэр, оношлогооны компьютер /Скайнер/, гидропресс, автомат кропны тос солигч, пүрш агшаагч, кропны домкрат, компрессор, дугуй задлагч, очлуур шалгагч, цэвэрлэгч, батарей цэнэглэгч, дизель форсунк тохируулагч, шалгагч, суурин өрөм, эд анги угаагч сав, тэнхлэг тохиргооны стэнд, 4 хөлт өргүүр, гагнуурын аппарат, А/С (air condition) цэнэглэгч, стартер болон генератор шалгагч стэнд, инжектор, форсунк шалгагч, дугуй тэнцвэржүүлэгч гэх мэт.
- **Багаж хэрэгсэл:** Тос шахагч, таслагч, хийн буу, гар дрилл, багажны шүүгээ, усны насос, тоос сорогч, дугуйт өргөгч дамократ, тортог хэмжигч, дискитэй ширээ, дөш, гидрийн шингэн солигч, тормозны шингэн солигч, үлээж цэвэрлэх хошуу, съёмник, слесарын иж бүрэн багаж, резьба татагч, салхины шил авагч, салон задлагч, мультиметр, ареометр, хөргөлтийн систем шалгагч, цахилгааны ком багаж, тормозны поршен агшаагч, товуд шахагч, хөдөлгүүрийн тосны даралт шалгагч, бензин насос шалгагч, батарей шалгагч, батарей холбогч, уртасгагч, зөөврийн гэрэл,

галын булан, анхны тусламжийн хайрцаг, хогийн сав, төмрийн хогны сав, хаягдал тосны сав, ариун цэврийн булан, ивүүр, тулгуур, тавиурууд, аккумулятор, динамометр /хэмжээт иш/, засварын программ, тосны шүүрний тайлагч, тусгай түлхүүр, түгжээ авагч, хомут авагч, шланг хавчигч, трубка малгайлагч, клапан шахагч, түлш цацалт тохируулагч /дизель/, ремень татлага, гинжин татлага, бензин, дизель хөдөлгүүрийн компресс хэмжигч, сийрэгжилт хэмжигч, бүх төрлийн түлхүүр багаж, бүх төрлийн торцов багаж, бүх төрлийн түргэн түлхүүр багаж, алх, лантуу, кольцо баригч, хуруувч авагч, кольцо тэлэгч, гильз сугалагч, уян соронз, хэмжих багаж хэрэгсэл /микрометр, нутрометр/, индикатор, телескопнутрометр, штангенциркуль гэх мэт.

- **Түүхий эд, материал:** Бензин, дизель түлш, бензин хөдөлгүүрийн тос, дизель хөдөлгүүрийн тос, ATF (automatic transmission fluid) шингэн, хөргөлтийн шингэн, редукторын тос, өтгөн тос, селькон, зэв арилгагч, коллектор цэвэрлэгч, тос арилгагч, автохимийн бүтээгдэхүүн, утас багцлагч, цахилгааны линт, гал хамгаалагчууд, А/С (air condition) перон, түгжээ, кноп, арчих материал, гарын тос угаагч, тасдагч ир, өрмийн хошуу, зүлгүүр, электрод, СО (нүүрс хүчлийн хий), цэвэрлэгээний сойз, төмрийн хөрөө ир, цаасны хутга, тестерийн батарей, тестерийн шуб, зөөврийн гэрлийн ламп, тахир голын гулсах холхивчний зай хэмжигч, очлуур гэх мэт.
- **ХАБЭА-н хэрэгсэл:** ХАБЭА-н шаардлагын дагуу анхны тусламжийн иж бүрдэл болон хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн бэлэн байдлыг хангана.

4. Ажлын байранд мөрдөгдөх норматив ишлэл

Ажлын байранд дараах хууль, дүрэм журам, стандартыг баримтална. Эдгээр баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журам
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
- MNS 5080:2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ
- MNS 5025:2001 Авто үйлчилгээ. Ерөнхий шаардлага
- MNS 4598:2011 Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага
- MNS 4599:2003 Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд
- MNS 4601:2011 Автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт
- MNS 4597:2014 Автомашины угаалгын үйлчилгээ. Ангилал. Ерөнхий шаардлага
- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 216 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын ажлын техникийн шаардлага"

5. Хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшил

5.1 Мэдлэг

- М 1. Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль, дүрэм, журам, стандарт
- М 2. Байгууллагын дотоод дүрэм, журам
- М 3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага
- М 4. Тээврийн хэрэгслийн төрөл, ангилал
- М 5. Автомашины бүтэц, шинэ хийц, загвар, онцлог
- М 6. Автомашины оношлогоо хийх арга
- М 7. Автомашины засвар ажил гүйцэтгэх
- М 8. Автомашины техникийн үйлчилгээний ажил гүйцэтгэх
- М 9. Засварын ажлын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл
- М 10. Техникийн товч тодорхойлолт, нэр томъёо
- М 11. Засварын ажлын материал, түүхий эд, сэлбэг, тос тосолгооны материал
- М 12. Механизм, системүүдийн ажиллах зарчим
- М 13. Техникийн зураг унших, ойлгож ашиглах
- М 14. Техникийн хүлцэл суулт
- М 15. Метал боловсруулах арга
- М 16. Хөдөлгүүрийн ангилал, бүтэц, ажиллах зарчим
- М 17. Автомашины механизм, системийн ажиллагаа, хийцийн онцлог
- М 18. Гадаад хэлний зохих мэдлэгтэй байх
- М 19. Техникийн материалын эсэргүүцэл, шинж чанар, бүтэц

5.2 Ур чадвар

- УЧ 1. Засварын тоног төхөөрөмж ашиглах, ажиллуулах
- УЧ 2. Засварын технологийн горимыг мөрдөх
- УЧ 3. Бодит нөхцлийг харгалзан өөрчлөлтөнд дасах
- УЧ 4. Мэдээлэл цуглуулах, ашиглах
- УЧ 5. Хөдөлмөрийн багаж хэрэгслийг зөв ашиглах
- УЧ 6. Ажлын байрны эмх цэгцийг хангах
- УЧ 7. Техникийн эд ангийг задлах угсрах технологийг баримтлах
- УЧ 8. Оношлогооны аппарат багаж хэрэгслийг ашиглах
- УЧ 9. Техникийн зураг өгөгдлийн дагуу эд анги агрегатыг засах
- УЧ 10. Нимгэн төмрийн дарханы ажил гүйцэтгэх
- УЧ 11. Техникийн материал, сэлбэг хэрэгслийг сонгох
- УЧ 12. Гагнуурын ажил гүйцэтгэх
- УЧ 13. Шаардлагатай материал, сэлбэг хэрэгслийг тооцоолон бодох
- УЧ 14. Хөдөлмөрийн сахилга батыг баримтлан хариуцлага хүлээх
- УЧ 15. Механизм системийн ажиллагааны зарчмыг сэтгэн бодох
- УЧ 16. Цахилгаан багаж хэрэгслийг ажиллуулах, ашиглах
- УЧ 17. Чанартай үйлчилгээ үзүүлэх ур ухаантай байх

5.3 Хандлага, төлөвшил

- Х 1. Мэргэжилдээ дуртай байх
- Х 2. Бие даан ажиллах
- Х 3. Багаар хамтран ажиллах
- Х 4. Цаг баримтлах
- Х 5. Арвич хямгач, цэвэрч нямбай, ажигч гярхай байх

- X 6. Эдийн засгийн хэмнэлттэй ажиллах
- X 7. Ажлын ачаалал даах
- X 8. Хариуцлагатай, бусдыг хүндэтгэн үздэг
- X 9. Зөв соёлтой харилцах
- X 10. Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хэвийн ажиллагааг хангадаг байх
- X 11. Багаж хэрэгслийг зориулалтын дагуу ашиглах
- X 12. Технологийн горимыг заавал мөрдөх
- X 13. Үйлчилгээнд чанарын баталгаа өгөх
- X 14. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг хангах
- X 15. Өгсөн ажил, даалгаврыг төгс гүйцэтгэх

6. Үүрэг ба ажилбарын жагсаалт

Автомашинь засварчин хийж гүйцэтгэх ажил үүргийг ажилбараар ангилан тодорхойлов. Мэргэжлийн боловсрол, сургалтаар олгох боломжгүй дадлага ажлыг ажлын байрны бодит орчинд хийж гүйцэтгэх шаардлагатай ажилбаруудыг (*) тэмдэглэгээтэй үзүүлэв.

Д/д	Үүрэг	Ажилбар
1	ХАБЭА-г хангаж ажиллах	<ul style="list-style-type: none"> - Толгой, нүүр, нүд хамгаалах хэрэгслийг хэрэглэх - Амьсгал, сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл хэрэглэх - Ажлын тусгай хувцас, ажлын тусгай гутал хэрэглэх - Эрсдэлийн үнэлгээ хийх - Ажлын байрны эрсдэлийг үнэлэх - Хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг бууруулах - Мэргэжлээс шалтгаалах өвчнөөс хамгаалах - Тэмдэг тэмдэглэгээг хэрэглэх - Цахилгаан гүйдэлд нэрвэгдэхээс хамгаалах арга хэмжээ авах - Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, түүнийг унтраах арга хэмжээ авах - Автомашинь хөдөлгүүр задлах, угсрах аюулгүй ажиллагааг хангах - Автомашинь шасси задлах, угсрах аюулгүй ажиллагааг хангах - Автомашинь техник үйлчилгээ хийх үеийн аюулгүй ажиллагааг хангах - Багаж хэрэгсэлийг ашиглах, ажиллах аюулгүй ажиллагааг хангах - Автомашинь өргүүр, домкратыг ажиллуулах аюулгүй ажиллагааг хангах - Автомашинь оношлох стенд техниктэй ажиллах аюулгүй ажиллагааг хангах - Дугуй задлах угсрах тоног төхөөрөмжтэй ажиллах аюулгүй ажиллагааг хангах - Автомашинь хөдөлгүүр, агрегатуудыг задлах угсрах тоног төхөөрөмжтэй ажиллах аюулгүй ажиллагааг хангах

2	Техникийн материалд механик боловсруулалт хийх	<ul style="list-style-type: none"> - Ашиглагдах материал сонгож, хэрэглэх - Хэмжих багаж ашиглаж хэмжээг тодорхойлох - Материалыг боловсруулалтанд бэлтгэх - Гар багаж ашиглаж механик боловсруулалт хийх - Цахилгаан багаж ашиглаж механик боловсруулалт хийх - Хийн багаж ашиглаж механик боловсруулалт хийх - Цахилгаан тоног төхөөрөмж ашиглаж механик боловсруулалт хийх - Хийн даралтат тоног төхөөрөмж ашиглаж механик боловсруулалт хийх - Шингэн даралтат тоног төхөөрөмж ашиглаж механик боловсруулалт хийх
3	Техникийн зураг ашиглах	<ul style="list-style-type: none"> - Зургийн төрлүүдийг ялгах - Хэмжих, масштаб, харьцааг тодорхойлох - Хэрэглээний зургуудтай танилцах - Эд ангийн тойм зураг унших - Эд ангийн ажлын зураг унших - Ерөнхий байдлын зураг унших - Угсрах зураг унших - Хэвийн хэмжээ, хазайлт тодорхойлох - Хэмжээний хэлхээсний тооцоо хийх - Стандартчилалыг тодорхойлох - Гадаргуугийн цэвэршилт тогтоох - Гадаргуугийн барзгаршилтыг тодорхойлох - Ажлын зураг дээрх техникийн шугам хоолой, тоног төхөөрөмжийн нэр томьёо, тэмдэг тэмдэглэгээ унших - Эд ангийн зүсэлтийн зураг дээрээс техникийн шугам хоолой, тоног төхөөрөмжийн хэмжээг тодорхойлох - Техникийн тойм зураг дээрээс гол шугамууд, тоног төхөөрөмжийн байрлалыг тодорхойлох
4	Автомашинны бүтэц зохион байгуулалтыг тайлбарлах	<ul style="list-style-type: none"> - Дотоод шаталтын хөдөлгүүрийн төрөл, ангиллыг нэрлэх - Хөдөлгүүрийн үндсэн эд ангийг тайлбарлах - Хөдөлгүүрийн үзүүлэлтүүд, нэр томьёог тоочих. - Дөрвөн тактын хөдөлгүүрийн ажиллах зарчмыг ярих - Хосолмол хөдөлгүүрийн бүтэц ажиллах зарчмыг тайлбарлах - Тахир гол шатуны механизмын бүтэц зохион байгуулалт ажиллагааны зарчмыг тайлбарлах - Эд ангиудыг таньж хийцийн онцлогийг тайлбарлах - Хий хуваарилах механизмийг бүтэц зохион байгуулалт ажиллагааны зарчмыг тайлбарлах - Хий хуваарилах механизмын төрөл ангиллыг тоочих - Эд ангиудыг таньж хийцийн онцлогийг тайлбарлах - Тосолгооны бодис, хөдөлгүүрийн тосны үүрэг, шинж чанарыг тайлбарлах - Тосолгооны системийг бүтэц зохион байгуулалт ажиллагааны зарчмыг тайлбарлах

		<ul style="list-style-type: none"> - Эд ангиудыг таньж хийцийн онцлогийг тайлбарлах - Хөргөлтийн системийг бүтэц зохион байгуулалт ажиллагааны зарчим ажиллагааг тайлбарлах - Хөргөх шингэний найрлага, төрлийг тайлбарлах - Дизель түлшний системийн бүтэц зохион байгуулалт ажиллагааны зарчмыг тайлбарлах - Бензин түлшний системийн бүтэц зохион байгуулалт ажиллагааны зарчмыг тайлбарлах - Хийн түлшний системийн бүтэц зохион байгуулалт ажиллагааны зарчмыг тайлбарлах - Эд ангиудыг таньж хийцийн онцлогийг тайлбарлах - Асаалтын системийн бүтэц ажиллагааг тайлбарлах - Электрон удирдлагатай асаалтын системийн бүтэц ажиллагааг тайлбарлах - Эд ангиудыг таньж хийцийн онцлогийг тайлбарлах - Авцуулах холбоо бүтэц зохион байгуулалт ажиллагааны зарчмыг тайлбарлах - Хурдны хайрцаг бүтэц зохион байгуулалт ажиллагааны зарчмыг тайлбарлах - Кардан ба хагас голын бүтэц зохион байгуулалт ажиллагааны зарчмыг тайлбарлах - Ерөнхий дамжуулга бүтэц зохион байгуулалт ажиллагааны зарчмыг тайлбарлах - Хүч дамжуулах ангийн эд ангиудыг таньж хийцийн онцлогийг тайлбарлах - Хамаарах ба үл хамаарах тэнхлэгийн бүтэц зохион байгуулалт ажиллагааны зарчмыг тайлбарлах - Гүүшингийн төрөл, бүтэц зохион байгуулалт ажиллагааны зарчмыг тайлбарлах - Дугуйн төрөл бүтэц ангилалыг тайлбарлах - Явах ангийн эд ангиудыг таньж хийцийн онцлогийг тайлбарлах - Жолооны системийн бүтэц зохион байгуулалт ажиллагааны зарчмыг тайлбарлах - Тоормосний системийн бүтэц зохион байгуулалт ажиллагааны зарчмыг тайлбарлах - Удирдлагын системийн эд ангиудыг таньж хийцийн онцлогийг тайлбарлах - Цахилгаан энерги хангах системийн эд ангиудыг төрөл, бүтэцийг тайлбарлах - Стартерын төрөл бүтэц, ажиллагааг тайлбарлах - Гэрэлтүүлгийн системийн бүтэц, төрөл, зориулалт, ажиллагааг тайлбарлах - Их биеийн цахилгаан тоноглолын бүтэц, төрөл, зориулалт, ажиллагааг тайлбарлах
--	--	---

5	Техникийн мэдээлэл олох	<ul style="list-style-type: none"> - Толь бичиг ашиглах - Техникийн эд ангийг гадаад хэлнээс тайлбарлах - Гадаад хэл дээрх мэргэжлийн үг хэллэгийг ашиглах - Мэдээлэл хайх, татах дамжуулах - Засварын программ хэрэглэх* - Интернет ашиглах - Засварын ажлын гарын авлагад тусгасан урьдчилсан анхааруулгыг мөрдөх* - Зааврын дагуу ажлын орчин сонгох* - Зааврын дагуу тоног төхөөрөмж, багаж сонгох* - Ашиглалтын зааврын дагуу ажиллах* - Задаргааны гарын авлагын зааврын дагуу ажиллах*
6	Автомашинд оношлогоо, техникийн үйлчилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - Хөдөлгүүрийн анхан шатны үзлэг хийх - Хүч дамжуулах ангийн анхан шатны үзлэг хийх - Явах ангийн анхан шатны үзлэг хийх - Удирдах системийн анхан шатны үзлэг хийх - Цахилгаан тоноглолын анхан шатны үзлэг хийх - Тослох системийн техникийн үйлчилгээ хийх - Хөргөлтийн системийн техникийн үйлчилгээ хийх - Асаалтын системийн техникийн үйлчилгээ хийх - Оруулах гаргах системийн техникийн үйлчилгээ хийх - Түлшний болон хорт бодисын хяналтын системийн техникийн үйлчилгээ хийх - Механизмын техникийн үйлчилгээ хийх - Хурдны хайрцгийн техникийн үйлчилгээ хийх - Кардан дамжуулга болон хагас голын техникийн үйлчилгээ хийх - Ерөнхий дамжуулгад техникийн үйлчилгээ хийх - Авцуулах холбооны техникийн үйлчилгээ хийх - Дугуйн техникийн үйлчилгээ хийх - Тэнхлэгийн техникийн үйлчилгээ хийх - Гүүшингийн техникийн үйлчилгээ хийх - Тормозны системийн техникийн үйлчилгээ хийх - Жолооны системийн техникийн үйлчилгээ хийх - Энерги хангах системийн техникийн үйлчилгээ хийх - Гэрэлтүүлгийн техникийн үйлчилгээ хийх - Их биеийн цахилгаан тоноглолын техникийн үйлчилгээ хийх - Авто машинд оношлогоо, техникийн үйлчилгээ хийх
7	Автомашин явах ангийг засварлах	<ul style="list-style-type: none"> - Хамаарах тэнхлэгийн эд ангийн гэмтлийг оношлох - Үл хамаарах тэнхлэгийн эд ангийн гэмтлийг оношлох - Тэнхлэгийн эд ангийг задалж угсрах - Дугуйн булыг задалж угсрах - Эд ангийн элэгдэл, гэмтлийг тодорхойлж засварлах - Тэнхлэг тохиргоо хийх - Гүүшингийн эд ангиудын гэмтлийг оношлох - Амортизаторыг задалж угсрах - Амортизатор тохируулагчийн гэмтлийг засварлах - Зөөллүүрийн эд ангийг задалж угсрах

		<ul style="list-style-type: none"> - Тэнцвэржүүлэгчийг задалж угсрах - Эд ангийн элэгдэл, гэмтлийг тодорхойлж засварлах - Дугуйг автомашинаас авах болон угсрах - Дугуйн гэмтлийг оношлох - Дугуйг задалж угсрах - Дугуйг засварлах - Дугуйн тэнцвэржүүлэлт хийх*
8	Автомашины удирдах механизмыг засварлах	<ul style="list-style-type: none"> - Үрлэн эрэгт жолооны системийн гэмтлийг оношлох - Механизмын эд ангийг задалж угсрах - Дамжуулгын эд ангийг задалж угсрах - Удирдлагын эд ангийг задалж угсрах - Хүчлүүрийн эд ангийг задалж угсрах - Эд ангийн гэмтлийг засварлах - Механизмын эд ангид тохиргоо хийх - Хэдрэг араат жолооны системийн гэмтлийг оношлох - Шингэнт хүчлүүрийн эд ангийг задалж угсрах - Цахилгаан хүчлүүрийн эд ангийг задалж угсрах - Цахилгаан хүчлүүрийн EPS (electric power steering) электрон удирдлагын блокны гэмтлийг засварлах - Эд ангийн гэмтлийг засварлах - Шингэнт тормозны системийн гэмтлийг оношлох - Тормозны төв цилиндрийг задалж угсрах - Зээрэнцэг тормозны ажлын цилиндрийг задалж угсрах - Барбант тормозны ажлын цилиндрийг задалж угсрах - Тормозны электрон удирдлагын гэмтлийг илрүүлж засварлах - Автомашины тормозны зээрэнцэг хүрд засах - Хийн тормозны системийн гэмтлийг оношлох - Хийн хураах системийн гэмтлийг засварлах - Хий хуваарилагч системийн гэмтлийг засварлах - Ажлын тормозыг засварлах - Зогсоолын тормозны гэмтлийг илрүүлэх - Тормозны эд ангийг задалж угсрах - Эд ангийн элэгдэл гэмтлийг тодорхойлох - Тормозны тохиргоо хийж ажиллагааг шалгах
9	Автомашины хүч дамжуулах ангийг засварлах	<ul style="list-style-type: none"> - Авцуулах холбооны гэмтлийг оношлох - Авцуулах холбооны эд ангийг задалж угсрах - Эд ангийн эвдрэлийг тодорхойлж засварлах - Авцуулах холбоонд тохиргоо хийж ажиллагааг шалгах - Механик хурдны хайрцгийн гэмтлийг оношлох - Автомат хурдны хайрцгийн гэмтлийг оношлох - Автомашинаас хурдны хайрцгийг тайлж авах ба суурилуулах - Хуваарилах хайрцгийг тайлж авах ба суурилуулах - Хуваарилах хайрцгийн эд ангийг задалж угсрах - Хурдны хайрцгийн эд ангийг задалж угсрах - Эд ангийн элэгдэл, гэмтлийг тодорхойлж засварлах

		<ul style="list-style-type: none"> - Автомашинаас кардан гол болон хагас голыг тайлж авах ба угсрах - Кардан голын нугасыг задалж угсрах - Хагас голыг задалж угсрах - Эд ангиудад үзлэг хийж элэгдэл,гэмтлийг тодорхойлж засварлах - Ерөнхий дамжуулгын гэмтлийг гэмтлийг оношлох - Ерөнхий дамжуулгын эд ангийг задалж угсрах - Дифференциалын эд ангийг задалж угсрах - Эд ангийн элэгдэл, гэмтлийг тодорхойлж засварлах - Ерөнхий дамжуулгад тохиргоо хийх - Дифференциал цоожлогчийг засварлах
10	Автомашины хөдөлгүүрийг засварлах	<ul style="list-style-type: none"> - Хөдөлгүүрийн хөргөх шингэн ба тосыг юүлэх - Хөдөлгүүрээс системүүд болон агрегатуудын эд анги, цахилгаан хэрэгсэлийг салгах - Хөдөлгүүрийг өргөгч ашиглан автомашинаас гаргаж авах - Хөдөлгүүрийг автомашинд суурилуулах - Хөдөлгүүрийг асааж шалгах - Механизмд хэмжих багаж, тоног төхөөрөмж ашиглан оношлогоо хийн гэмтлийг илрүүлэх - Механизмын эд ангиудыг задлаж, угсрах - Эд ангийн элэгдлийг тодорхойлж засварлах - Механизмын тохиргоог хийж - Хөдөлгүүрийг асааж ажиллагааг шалгах - Системийн ажиллагааг шаардлагатай багаж, тоног төхөөрөмж ашиглан оношилж гэмтлийг илрүүлэх - Системийн эд ангиудыг задалж, угсрах - Эд ангиудын элэгдэл гэмтлийг тодорхойлох - Хөргөх шингэн болон тосыг хөдөлгүүрт хийн асааж шалгах - Системийн ажиллагааг шаардлагатай багаж, тоног төхөөрөмж ашиглан оношилж гэмтлийг илрүүлэх - Системийн эд ангиудыг задалж, угсрах - Эд ангиудын элэгдэл гэмтлийг тодорхойлох - Системийн эд ангиудын тохиргоо хийх - Засварын дараах үзлэгийг хийн асааж шалгах - Системийн ажиллагааг шаардлагатай багаж, тоног төхөөрөмж ашиглан оношилж гэмтлийг илрүүлэх - Системийн эд ангиудыг задалж, угсрах - Эд ангиудын элэгдэл гэмтлийг тодорхойлох - Засварын дараах үзлэгийг хийн асааж шалгах
11	Автомашины цахилгаан, электрон тоноглолыг засварлах	<ul style="list-style-type: none"> - Батарейн гэмтлийг оношлох, засварлах - Генераторын цахилгаан хэлхээний гэмтлийг оношлох - Генераторыг задалж угсрах - Генераторын эд ангийн гэмтлийг тодорхойлж засварлах - Стартерын цахилгаан хэлхээний гэмтлийг оношлох - Стартерыг задалж угсрах

		<ul style="list-style-type: none"> - Стартерын эд ангийн гэмтлийг тодорхойлж засварлах - Их гэрлийн цахилгаан хэлхээний гэмтлийг тодорхойлж засварлах - Оврын цахилгаан хэлхээний гэмтлийг тодорхойлж засварлах - Эргэх болон ослын дохионы цахилгаан хэлхээний гэмтлийг тодорхойлж засварлах - Бүхээгийн гэрэлтүүлгийн цахилгаан хэлхээний гэмтлийг тодорхойлж засварлах - Тормозны болон ухрах гэрлийн цахилгаан хэлхээний гэмтлийг тодорхойлж засварлах - Нэмэлт гэрэлтүүлгийн цахилгаан хэлхээний гэмтлийг тодорхойлж засварлах - Хаалганы цоожлох системийн цахилгаан хэлхээний гэмтлийг тодорхойлж засварлах - Шил өргөгчийн цахилгаан хэлхээний гэмтлийг тодорхойлж засварлах - Шил арчигч болон угаагчийн цахилгаан хэлхээний гэмтлийг тодорхойлж засварлах - Цан арилгагч цахилгаан хэлхээний гэмтлийг тодорхойлж засварлах - Тольны удирдлагын цахилгаан хэлхээний гэмтлийг тодорхойлж засварлах - Агаар сэлгэх системийн цахилгаан хэлхээний гэмтлийг тодорхойлж засварлах - Суудал тохируулах болон халаах цахилгаан хэлхээний гэмтлийг тодорхойлж засварлах - Асаах түлхүүрийн аюулгүй байдлын системийг оношлох, засварлах - Дохиоллын системийг оношлох засварлах - Хийн дэр оношлох засварлах - Хөдөлгүүрийн удирдлагын электрон системийг оношлох засварлах - Хүч дамжуулах ангийн электрон системийг оношлох засварлах - Их биеийн электрон системийг оношлох засварлах - Явах ангийн электрон системийг оношлох засварлах
--	--	---

7. Ажлын байр бусад албан тушаалын уялдаа холбоо

Автомашинь засварчны бусад албан тушаалтантай ажиллах уялдаа холбоог дараах байдлаар дүрслэн харуулав.



Жич: Дээрх дүрслэлд харуулсан бүтэц нь тухайн автозасварын газрын бүтэц зохион байгуулалт, хүчин чадлаас хамааран харилцан адилгүй болно.

Тухайн ажилтныг удирдах албан тушаал болон удирдуулан ажиллах ажилтныг босоо тэнхлэгээр харуулж байгаа бөгөөд энэ нь түүний өсч, дэвших боломжийг мөн илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, Автомашинь засварчин нь авто засварын газрын удирдлага, инженер, мастерын хяналтан дор ажиллаж, дадлагын оюутан буюу туслах ажилтныг удирдан, хэвтээ тэнхлэгт байрлах ажилтнуудтай хамтран ажиллана.

8. Техникийн эсвэл мэргэжлийн боловсрол олгох байгууллага болон ажил олгогчийн мэдээлэл

Иргэн тухайн мэргэжлээр суралцах эсвэл ажил хайж байгаа тохиолдолд дараах мэдээлэлтэй танилцаж, сонголтоо хийх боломжтой.

Техникийн болон мэргэжлийн боловсрол олгох байгууллагуудын мэдээлэл	Ажил олгогч байгууллагуудын мэдээлэл
<p>Тухайн мэргэжлээр бэлтгэдэг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон политехник коллежийн талаарх мэдээллийг дараах вэб хуудаснаас авна уу.</p> <p>http://www.asc.mn</p>	<p>Тухайн мэргэжлээр ажилтан хайж байгаа байгууллагуудын талаарх мэдээллийг дараах вэб хуудаснаас авна уу.</p> <p>http://hudulmur-halamj.gov.mn/job/list</p>

9. Автомашины засварчин мэргэжлээр ажил мэргэжлийн лавлахыг боловсруулж, баталгаажуулсан төлөөлөл

Ажил мэргэжлийн лавлахын ДАКУМ шинжилгээг боловсруулахад оролцсон багийн гишүүд

- | | |
|------------------|---|
| 1. Ш.Давааням | “Хаан дэвшил” ХХК-ийн Сервис менежер |
| 2. Д.Ариунболд | “Монгол Хьюандай” ХХК-ийн Сервис менежер |
| 3. М.Батбилэг | “Моннис моторс” ХХК-ийн Сервис менежер |
| 4. Д.Батсайхан | “МСМ” группын Мастер |
| 5. Г.Цогбадрах | “Mon car” ХХК-ийн Засварчин |
| 6. З.Очирбаяр | “Avto dip” ХХК-ийн Засварчин |
| 7. В.Мягмар-Очир | “Mira” ХХК-ийн Засварчин |
| 8. Л.Долгорсүрэн | Хангайн БАЗТ Хөтөлбөр хариуцсан арга зүйч |
| 9. Т.Ганпүрэв | “My Car” ХХК-ийн Засварчин |
| 10. Г.Ариунтөгс | “Deluxe Авто төв”-ийн Засварчин |
| 11. Д.Энхжаргал | “Car stars” ХХК-ийн Засварчин |
| 12. Б.Чулуун | “Авто Их Биеийн засвар эрхлэгчдийн холбоо”-ны Тэргүүн |

Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулахад ашигласан ДАКУМ шинжилгээг баталгаажуулсан:

- | | |
|------------------|---|
| 1. Б.Энхбаатар | “MSM” группын Салбарын захирал |
| 2. Varun Shinha | “MSM” группын Зөвлөх |
| 3. Г.Гантулга | “Мон-Кара” ХХК-ийн Мастер |
| 4. Б.Чулуун | “Авто Их Биеийн засвар эрхлэгчдийн холбоо”-ны Тэргүүн |
| 5. Б.Гантөмөр | “Мон-Кара” ХХК-ийн Механик инженер |
| 6. Д.Идэрзориг | “MERA” ХХК-ийн Мастер |
| 7. С.Ганзориг | “MERA” ХХК-ийн Менежер |
| 8. П.Лхагвасүрэн | “Моннис моторс” ХХК-ийн Ахлах механик |
| 9. М.Бат-Эрдэнэ | “Моннис моторс” ХХК-ийн Сэлбэгийн менежер |
| 10. Б.Мөнхтуяа | “Хаан дэвшил” ХХК-ийн Хүний нөөцийн ажилтан |
| 11. Г.Мэндбаяр | “Хачи” ХХК-ийн Захирал |
| 12. Д.Ариунболд | “Auto dip” ХХК-ийн Хрел Үйл ажиллагааны менежер |
| 13. З.Очирбаяр | “Auto dip” граж мастер |
| 14. Г.Батзориг | “Авто Их Биеийн засвар эрхлэгчдийн холбоо”-ны Менежер |
| 15. Д.Батсайхан | “MSM” группын Мастер |

Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулахад ашигласан ДАКУМ шинжилгээг хянасан авто замын салбарын экспертүүдийн төлөөлөл:

- | | |
|------------------|--|
| 1. И.Гончигзэвэг | Монголын Авто Замчдын Холбооны Сургалт, арга зүйн зөвлөлийн дарга, Монгол Улсын Зөвлөх инженер |
| 2. Ч.Лхагважав | Монголын Авто Замчдын Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, “ЛАБО” ХХК-ийн Зөвлөх инженер, доктор |
| 3. Ч.Долгорсүрэн | Монголын Авто замчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, ТТДС-ийн Авто замын тэнхимийн эрхлэгч, Зөвлөх инженер |
| 4. Б.Сайханбилэг | “Эрч гранд” ХХК Ерөнхий механик, Авто замын инженер |

Ажил мэргэжлийн дүн шинжилгээний чиглүүлэгчид:

1. Ё.Бадамхатан ДАКУМ I зэргийн гэрчилгээт Сургагч багш, Хангайн БАЗТ-ийн менежер
2. Ч.Эрдэнэтуяа ДАКУМ I+ зэргийн гэрчилгээт Сургагч багш, Өмнөговь аймгийн Политехник Коллежийн Сургалтын албаны дарга
3. Б.Цолмон ДАКУМ I+ зэргийн гэрчилгээт Сургагч багш, Төв аймгийн Заамар сум дахь МСҮТ-ийн Арга зүйч

Ажил мэргэжлийн лавлахын загварыг боловсруулж, хянасан зөвлөхүүд:

1. Д.Адилбиш ХНХЯ-ны МБСБХЗГ-ын Ахлах мэргэжилтэн
2. Ц.Ганчимэг АХБ-ны ХЭУЧД төслийн ЧССҮ-ний мэргэжилтэн
3. Д.Энхбаатар ЧССҮ-ний Үндэсний зөвлөх
4. Г.Батчимэг ЧССҮ-ний Зөвлөх

10. Автомашины засварчин мэргэжлийн үүрэг, ажилбарын зураглал (ДАКУМ шинжилгээ)

		АЖИЛБАР														
ҮҮРЭГ																
A	Ажлын байр бэлтгэх	A-1 Хувийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх	A-2 Өөрийгөө ажилд бэлтгэх	A-3 ХАБЭА-н зааварчилгаа авах	A-4 Ажлын даалгавар авах	A-5 Ажлын багаж хэрэгсэл сонгох	A-6 Ажлын байрны тоног төхөөрөмжийг сонгох	A-7 Ажлын байрны эрсдлийг үнэлэх	A-8 Ажлын байрны аюулгүй байдлыг хангах	A-9 Ажлын байрыг цэвэрлэх	A-10 Хаягдал материалыг горимын дагуу хадгалах					
		ACA	ACA	ACA	ACA	ABA	AAA	AAA	AAA	ACA	ABA					
B	АМ-д оношлогоо хийх	B-1 Үйлчлүүлэгчийг хүлээж авах	B-2 АМ-ны хөдөлгүүрийг оношлох	B-3 АМ-ны хүч дамжуулах ангийг оношлох	B-4 АМ-ны явах ангийг оношлох	B-5 АМ-ны тормозны системд оношлох	B-6 АМ-ны жолооны механизмд оношлох	B-7 АМ-ны цахилгаан тоноглолд оноших	B-8 АМ-ны электрон системд оношлогоо хийх	B-9 АМ-ны их биед ерөнхий үзлэг хийх						
C	АМ-д техник үйлчилгээ хийх	C-1 АМ-ны тосолгооны системд ТҮ хийх	C-2 АМ-ны хүч дамжуулах ангид ТҮ хийх	C-3 АМ-ны явах ангид ТҮ хийх	C-4 АМ-ны тормозны системд ТҮ хийх	C-5 АМ-ны жолооны механизмд ТҮ хийх	C-6 АМ-ны дугуйн байрлал солих	C-7 АМ-ны тэжээлийн системд ТҮ хийх	C-8 АМ-ны хөргөлтийн системд ТҮ хийх	C-9 АМ-ны асаалтын системд ТҮ хийх	C-10 АМ-ны механик хурдны хайрцагт ТҮ хийх	C-11 АМ-ны автомат хурдны хайрцагт ТҮ хийх	C-12 Бүхээгийн агааржуулалтын системд ТҮ хийх	C-13 Ерөнхий дамжуулах ангид ТҮ хийх	C-14 Хөдөлгүүрийн агааржуулалтын ТҮ хийх	C-15 АМ-ны цахилгаан тоноглолд ТҮ хийх
D	АМ-ны хөдөлгүүрт засвар хийх	D-1 АМ-ны хөдөлгүүрийг тайлж авах	D-2 АМ-ны хөдөлгүүрийг цэвэрлэх	D-3 АМ-ны хөдөлгүүрийг задлах	D-4 Тахир голт шатуны механизмын үзлэг хийх	D-5 Хий хуваарилах механизмд үзлэг хийх	D-6 Хөдөлгүүрийн шаардлагатай эд ангиудыг солих	D-7 Хөдөлгүүрийн эд ангиудыг угсрах	D-8 АМ-ны хөдөлгүүрийн тохиргоо хийх	D-9 АМ-ны хөдөлгүүрийг суурилуулах	D-10 АМ-ны хөдөлгүүрийн тос шингэнийг хийх	D-11 Хөдөлгүүрийн хөргөлтийн системийг засах	D-12 Хөдөлгүүрийн тосолгооны системийг засварлах	D-13 АМ-ны асаалтын системийг засварлах	D-14 АМ-ны тэжээлийн системийг засварлах	D-15 АМ-ны хөдөлгүүрийг асааж шалгах
E	АМ-ны хүч дамжуулах ангид засвар хийх	E-1 АМ-ны авцуулах холбоог засварлах	E-2 АМ-ны автомат хурдны хайрцаг засварлах	E-3 АМ-ны механик хурдны хайрцаг засварлах	E-4 АМ-ны туслах хурдны хайрцагны засварлах	E-5 Хурдны хайрцагны хос тросыг засварлах	E-6 АМ-ны кардан гол засварлах	E-7 АМ-ны тулгуур холхивч засварлах	E-8 АМ-ны редуктор засварлах	E-9 АМ-ны хагас гол засварлах	E-10 АМ-ны таван бул засварлах					
F	АМ-ны гүүшинд засвар хийх	F-1 АМ-ны амортизатор солих	F-2 АМ-ны нум пүрш солих	F-3 АМ-ны гарны втулка солих	F-4 АМ-ны тэнцүүлэгч солих	F-5 АМ-ны тэнхлэгийн холбоос татуурга солих	F-6 АМ-ны цаф солих	F-7 АМ-д тэнхлэг тохиргоо хийх	F-8 АМ-ны дугуй засварлах	F-9 АМ-ны кузов өргөгч засварлах	F-10 АМ-ны арлын тулгуур резин солих					
G	АМ-ны тормозны системийг засварлах	G-1 АМ-ны тормозны төв аппарат засварлах	G-2 АМ-ны тормозны трубка солих	G-3 АМ-ны ажлын тормоз засварлах	G-4 АМ-ны зогсоолын тормоз засварлах	G-5 АМ-ны тормозны зээрэнцэг хурд засварлах	G-6 АМ-ны хүчлүүр солих	G-7 АМ-ны хийн тормозны системийг засварлах	G-8 АМ-ны шингэн тормозны систем засварлах	G-9 АМ-ны цахилгаан тормозны систем засварлах	G-10 АМ-ны хосолсон тормозны систем засварлах					
H	АМ-ны жолооны механизмыг засварлах	H-1 АМ-ны жолооны хүрд засварлах	H-2 АМ-ны жолооны нугасан холбоос солих	H-3 АМ-ны жолооны аппарат засварлах	H-4 Жолооны гидронасос засах	H-5 Жолооны гидрийн шланг солих	H-6 Жолооны цахилгаан аппарат засварлах	H-7 Жолооны амортизатор солих	H-8 АМ-ны тэнхлэг тохиргоо хийх							
I	АМ-ны цахилгаан тоноглолыг засварлах	I-1 АМ-ны стартер засварлах	I-2 АМ-ны генератор засварлах	I-3 АМ-ны гэрэлтүүлгийг засварлах	I-4 АМ-ны хаалганы цоож засварлах	I-5 АМ-ны шил арчигч засварлах	I-6 АМ-ны шил өргөгч засварлах	I-7 АМ-ны эйркондейшн засварлах	I-8 АМ-ны ослын дэр солих	I-9 Бүхээгний цахилгаан тт-ийг засах						
J	АМ-ны электрон системийг засварлах	J-1 Хөдөлгүүрийн е/системийг засварлах	J-2 Явах ангийн е/системийг засварлах	J-3 Тормозны е/системийг засварлах	J-4 Жолооны механизмын е/системийг засварлах	J-5 Хурдны хайрцагийн е/системийг засварлах	J-6 Туслах х/х-ийн е/системийг засварлах	J-7 Хамгаалах е/системийг засварлах	J-8 Хурдны хяналтын е/системийг засварлах	J-9 Асаалтын е/системийг засварлах	J-10 Хөргөлтийн е/системийг засварлах	J-11 Тэжээлийн хяналтын е/системийг засах	J-12 Хянах хэмжих хэрэгслийн е/системийг засварлах	J-13 Аюулгүйн е/системийг засварлах	J-14 Тэнцвэр-жүүлэлтийн е/системийг засварлах	J-15 Тогтвор-жилтыне системийг засварлах
K	АМ-ны кузовын гэмтлийг засварлах	K-1 АМ-ны кузовын гэмтлийг тодорхойлох	K-2 АМ-ны кузовын эд ангийг задлах	K-3 АМ-ны кузовын сэв гажааг гаргах	K-4 АМ-ны кузовын гэмтэлтэй хэсэгт замаска тавих	K-5 АМ-ны кузовын эд ангиудыг угсрах	K-6 Будгийн камерийг ажилд бэлтгэх	K-7 АМ-г будалтын өмнө цэвэрлэх	K-8 АМ-нд суурь будаг хийх (гүрэнт,улаан замаска)	K-9 АМ-ыг будах өнгө гаргах	K-10 АМ-г үндсэн өнгөөр будах	K-11 Будагдсан эд ангиудыг горимын дагуу хатаах	K-12 АМ-ыг үйлчлүүлэгчид хүлээлгэж өгөх			
		AAA	AAA	AAA	ABA	AAA	ACA	ACA	ACA	AAA	AAA	AAA	AAA	AAA	AAA	AAA

ТЭМДЭГЛЭЛ: Саарал өнгөтэй хэсэгт ажлын байран дээр ирэхээс өмнө сургалтын байгууллагаар олгох ажилбарыг заасан бөгөөд үүнийг сургалтын хөтөлбөрийн агуулгад заавал тусгана. Цагаан толгойн гурван үсгийн дарааллаар чухал, хүнд, давтамжийн үзүүлэлтүүдийн харьцангуй түвшинг илэрхийлдэг. Ингэхдээ эхний үсэг нь чухлын зэргийг (А-маш чухал, В-чухал, С-чухал биш), хоёр дахь үсэг нь ажилбарын хүндрэлийн түвшинг (А-маш хүнд, В-хүнд, С-хүнд биш), гурав дахь үсэг нь ажилбарыг гүйцэтгэх давтамжийг (А-байнга, В-заримдаа, С-ховор) илэрхийлнэ. Жишээлбэл: Ажилбарыг ABC гэж тэмдэглэсэн бол тухайн ажилбар нь маш чухал, хүнд, ховор гүйцэтгэдэг ажилбар гэсэн утгатай.

ТОВЧЛОЛ: АМ-Автомашин, ХАБЭА-Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, ТҮ-техник үйлчилгээ, е/систем- электрон систем, Т/т – тоног төхөөрөмж,